

БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үрдүн	Үнэлгээ
НЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ			
1	Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	<p>Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг, төрөөс баримтлах салбарын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийг 4 бүлэг, 73 зорилт, 268 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулаа.</p> <p>Аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг ЗДТГ-ын үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөө /2015-2018/, аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг баримт бичгүүдтэй уялдуулан 5 бүлэг, 34 арга хэмжээг тусган хэрэгжүүлж, 92.6 хувьтай дүгнэгдлээ.</p> <p>“Журам батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол, “Журам батлах тухай” аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан журмуудыг үндэслэн төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ ил тод байдлыг 4 үзүүлэлтээр гаргаж үнэлснээр, төрийн болон төсөвт 190 байгууллагууд "Ил тод байдлын самбар"-ыг тогтмол ажиллуулж хэвшсэн.</p> <p>Аймгийн Засаг даргаас дэргэдэх агентлаг, төсөвт байгууллагуудын дарга нартай байгуулж буй үр дүнгийн гэрээнд жил бүр иргэдэд бодлого шийдвэрээ сурталчлахад зориулж хөрөнгө төсөвлөх тухай арга хэмжээ тусган хэрэгжүүлсний үр дүнд төрийн байгууллага бүр цахим хуудастай болж, мэдээ, мэдээлэл, зарыг дамжуулан, иргэдийн санал, санаачлагыг цахимаар аван бодлого шийдвэртээ тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Аймгийн цахим хуудсанд 200 гаруй мэдээ, мэдээлэл, аймгийн Засаг даргын 646 захирамж, ЗДТГ-ын даргын 103 тушаалыг бүрэн байршуулж, Төрийн албаны салбар зөвлөлийн цэсийг нэмж, өргөтгөн ажиллаж байна.</p>	100.0
2	Албан хаагчийн ёс зүйн дүрэм;	<p>“Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг өндөржүүлэх тухай” аймгийн Засаг даргын 2009 оны 01 дүгээр албан даалгавар, Төрийн үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрмийг аймгийн Засаг даргын захирамжаар баталж, биелэлтийг тооцон ажиллаж байна.</p> <p>2016 оны байдлаар төрийн захиргааны 16 албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулснаас сануулах сахилгын шийтгэл 2, цалингийн хэмжээг бууруулах 12, ажлаас халах 2 албан хаагчид тус тус сахилгын шийтгэл ногдуулжээ.</p> <p>Тайлант онд Мэдээлэл, шуурхай удирдлагын төвд 857 гомдол ирүүлсний 66 буюу 7.7 хувь нь төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, ажлын хариуцлагатай холбоотой гомдол ирүүлсэн нь урьд оноос 40 гомдлоор өссөн байна</p>	90.0

		<p>Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Эмч мэргэжилтний ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцох журам”-ын хэрэгжилтийг ханган эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын хариуцлага алдсан, ёс зүйгүй үйлдэл бүрт хариуцлага тооцох механизм бүрдүүлснээр зөрчил, дутагдлыг шуурхай илрүүлэн, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, бие биенээсээ харилцан суралцах нөхцөл бүрдэж, иргэдийн сэтгэл ханамж 13.6 хувиар дээшилж, Ёс зүйн салбар хороонд ирсэн гомдлын тоо 3 дахин буурсан байна.</p> <p>Аймгийн Боловсрол, соёлын газрын дэргэдэх багшийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хянан шийдвэрлэх “Ёс зүйн зөвлөл”-өөс ЕБС, СӨББ-ын багш, удирдах ажилтанд холбогдох нийт 17 өргдөл, гомдлын дагуу 1 удирдах ажилтныг тушаал бууруулах, 8 багшид сануулах арга хэмжээ авч, 8 асуудлыг эвлэрүүлэн ойлголцуулав. Салбарын хүрээнд ёс зүй, ажлын хариуцлага алдсан 215 хүнд сахилгын шийтгэл ноогдууллаа.</p> <p>Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдаанаар төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв олгох асуудлыг хэлэлцэж, аймгийн Засаг даргын захирамжаар төрийн захиргааны 32 албан хаагчид шинээр зэрэг дэв олгож, 67 албан хаагчийн зэрэг дэвийг дэвшүүлэн олголоо.</p>	
3	Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь;	<p>Төрийн байгууллагууд цахим хуудасны “холбоо барих” буландаа албан хаагчдын хариуцсан ажил, харилцах утасны дугаарыг ил тод байрлуулж, аймаг, сум, байгууллагын удирдлагууд иргэдийг өдөр бүр хүлээн авч уулзан ажиллаж байна.</p> <p>Сумдын ЗДТГазар, төсөвт байгууллагууд ээлжийн 74 хөтөч ажиллуулж, иргэдэд мэдээлэл лавлагаа өгч шуурхай үйлчлэснээр үйлчилгээний чанарт ахиц гарч байна.</p> <p>Аймгийн ЗДТГ болон зарим агентлагууд албан хаагчдын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй, ил тод байлгах зорилгоор ажлын өрөөны хаалганы гадна талд гадуур ажилтай, хуралтай, ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй, ажиллаж байгаа гэсэн тэмдэглэгээг ажилтнуудын нэрээр хийж байрлуулснаар иргэд хүлээгдэлгүй үйлчлүүлж байна.</p> <p>Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг “Аймгийн ИТХ, ЗДТГазраас иргэдийг хүлээн авах журам” тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 105 дугаар тогтоол, “Иргэдээс аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журам” тухай Засаг даргын 2008 оны, 44 дүгээр захирамжаар батлагдсан журмын хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна.</p>	100.0
4	Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт;	<p>Аймгийн цахим хуудас /www.uvurkhangai.mn/-д төрийн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэн тусгай зөвшөөрөл, үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамж, үйлчилгээний үнийн жагсаалт, хяналт шалгалтын төлөвлөгөө зэрэг цэсээр өргөтгөснөөр цахим болон пэйж хуудас өдөрт 200-300 хандалтаар өссөн</p>	100.0

		<p>байна.</p> <p>Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс зэрэг агентлагууд байгууллагын цахим хуудаснаа салбарын үндсэн үйлчилгээг иргэдэд ойлгомжтой байдлаар хүргэх, хялбаршуулах зорилгоор “Туслах цэс”, “Шалгах мэдээлэл” “Зөвлөгөө” зэрэг булан нээж санал хүсэлт, мэдээллээ цахимаар авах боломжтой болгон өргөтгөсөн нь иргэдэд хамгийн хүрсэн үйлчилгээ боллоо.</p> <p>Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн www.ndaatgal.ov.gov.mn цахим хуудсаар салбарын үндсэн үйлчилгээнээс гадна “Таны туслах”, “Шалгах мэдээлэл” булан нээж санал хүсэлт, ажил олгогчийн жирэмсэн амаржсан ба хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж тооцох, хөнгөлөлттэй үнээр үйлчлэх эмнэлэг, эмийн сан, рашаан сувилал, даатгуулагчийн эрүүл мэндийн шимтгэл төлсөн эсэхийг шалгах систэм, өндөр насны тэтгэврийн бодолтоо шалгах, ажилласан жил, нийгмийн даатгалын мэдээллээ цахимаар авах, хэрэглэгчдийн үнэлгээг авах боломжтой болгон өргөтгөсөн нь сайн жишээ болон хэрэгжиж байна.</p>	
5	Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар;	<p>Монгол улсын <i>ᠴᠠᠨᠭᠡᠢ ᠠᠳᠠᠳᠤᠢ ᠠᠢᠶᠢ ᠠᠡᠢ</i> иргэдийн Өөлөөлөгчдийн Өурлаас гаргасан <i>᠔ᠢ ᠠᠢ ᠢ ᠡ, ᠔ ᠡᠡᠠᠶᠤᠳᠦᠳᠦᠢ</i> <i>ᠵᠡᠡ ᠠᠭᠡᠡᠠᠳᠠᠳᠠᠢ ᠠᠠᠠ ᠠᠶᠡᠳᠡᠳᠡᠶᠡᠳᠡ ᠠᠢ ᠡᠶᠢ</i> <i>᠔ᠦᠳᠦᠶᠡᠵᠡᠶᠡ</i> аймгийн хэмжээнд мөрдөж байгаа эрхзүйн актуудад хяналт-шинжилгээ хийж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад чирэгдэл, хүнд суртал бий болгосон дүрэм, журам зааврыг цэгцлэх зорилтын хүрээнд 2005-2016 оны аймгийн Засаг даргын 3608 шийдвэрийг цахим хэлбэрт шилжүүлж, 11356 эрх зүйн актад нягтлан шалгалт хийж, 5 шийдвэрийг хүчингүй болгож, Захиргааны ерөнхий хуулийн дагуу дахин боловсруулан шийдвэрт нэмэлт өөрчлөлт орууллаа.</p> <p>Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, төсвийн бусад менежерүүдээс баталгаажигдсан 2016 оны нийт 1520 шийдвэрийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, шинжилгээ хийж, эрх зүйн актын зөрчлийг арилгуулахаар дүгнэлтийг холбогдох газруудад хүргүүлэв.</p> <p>“Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын хүрээнд бүтцэд өөрчлөлт орсон аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч Боловсрол, соёл, урлагийн газар, Орон нутгийн өмчийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар зэрэг агентлагуудын дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг Засаг даргын захирамжаар шинэчлэн батлав.</p>	100.0
1.2	Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн	<p>Засгийн газрын 2016 оны 141 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2016 оны а/239 дүгээр захирамжаар Арвайхээр сумын “Нэг цонхны үйлчилгээний төв”-ийг “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв” болгон өөрчлөн зохион байгуулж, орон нутгийн 5.5 сая төгрөгийн хөрөнгөөр дотоод сүлжээ, дараалал зохицуулах системийн шинэчлэл, иргэний бүртгэлийг шилэн кабельд холбох, хаяг шинэчлэх,</p>	100.0

	байх;	<p>техник хэрэгслийн асуудлыг шийдвэрлэснээр төрийн үйдчилгээний чанар, хүртээмж сайжирлаа.</p> <p>Аймгийн хэмжээнд Тарагт, Арвайхээр сумдаас бусад 17 сумд, хөдөөгийн багийн иргэдэд төрийн мэдээллийг хүргэх зорилгоор мессеж мэдээ мэдээлэл, зар, сэрэмжлүүлэг, цаг агаарын мэдээ, зэргийг шуурхай мэдээлж хэвшлээ. Эдгээр сумдын иргэдэд нийт 59885 удаа мессеж илгээсэн байна.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газар, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” хөтөлбөр хамтран “Орон нутгийн цогц хөгжил- 4 талын түншлэл” төслийг Өвөрхангай аймагт хэрэгжүүлэн, талуудын хамтын ажиллагаа, үр дүнг сайжруулах зорилгоор 4 талт түншлэлийн зөвлөлийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан төслийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Энэ хүрээнд “Төрийн байгууллагын мэдээлэл дамжуулах хурдыг нэмэгдүүлэх” төсөл шалгарч 5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч хэрэгжихээр боллоо.</p> <p>Хайрхандулаан, Төгрөг, Тарагт, Богд, Уянга, Гучин-Ус, Бүрд, Баянгол, Өлзийт, Хужирт, Хархорин сумдын дулааны зуухыг удирдах үйл ажиллагааны үр дүнд харгалзан менежментийн гэрээгээр хувьчлах шийдвэрийг гаргаж, нийт 350.0 сая төгрөгөөр үнэлэгдсэн орон нутгийн өмчийг хувийн хэвшилд шилжүүллээ. Дээрх сумдын дулааны зуухыг хувьчилж авсан аж ахуйн нэгжүүд нийт 874.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж, энэ хэмжээгээр улсын болон орон нутгийн төсвөөс гарах хөрөнгө оруулалтыг зардлыг хэмнэж, сумдыг төвлөрсөн дулаан хангамжтай болгоод байна.</p>	
1.3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;	<p>Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх ажлын хүрээнд орон нутгийн 4 телевиз, 2 сонин, 1 сэтгүүл, 1 радиогоор төрийн бодлого, шийдвэр, орон нутгийн цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор гэрээ байгуулан ажиллаж 35.0 сая төгрөгийн санхүүжилт олгов.</p> <p>Иргэдэд төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, түргэн шуурхай хүргэх зорилгоор аймгийн Засаг дарга 7 хоног бүрийн Мягмар гарагт аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, алба, төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нарын нэгдсэн шуурхай хурлыг зохион байгуулж хэвшээд байна. Энэ онд нийт 22 удаагийн хурлыг зохион байгуулж иргэдийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар 34 удаагийн мэдээллийг сонсч, 7032-1111 утсанд иргэдийн ирүүлсэн санал, гомдлын шийдвэрлэлт, хариу өгсөн байдалд дүгнэлт хийж, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар үүрэг чиглэл өгч гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харъяалагдах 181 байгууллага шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартын төсвийн мэдээллээ олон нийтэд ил тод мэдээллэн ажиллаж байна.</p>	100.0

		Мэдээллээ бүрэн гүйцэт үнэн зөв тавьж буй байлдалд аймгийн Аудитын газар, Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт тавьж зөвлөмж ирсний дагуу нэр дурдагдсан албан байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт шийдвэрийг хүргүүлж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллалаа. Илэрсэн зөрчил болон хуулийн хэрэгжилтийг төсвийн менежерүүдийн 7 хоног бүрийн шуурхай хуралдаан дээр 4 удаа танилцуулж, шилэн дансны шинэ цахим хуудсыг хэрхэн ашиглах, мэдээллийг хэрхэн байршуулах талаар сумдын Санхүүгийн албадын 65 нягтлан бодогчид, сумдын Засаг дарга, ИХТ-ийн дарга нарт тус бүр 1 удаагийн сургалт, мэдээллийг хийж, бүх шатны төсвийн захирагч нарт гарсан зөрчлийг арилгах, засаж залруулах талаар заавар зөвлөмж бүхий 1 албан тоот, аймгийн Засаг даргын албан даалгавар гарган хүргүүлж ажиллалаа.	
1.4	Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх;	<p>Аймгийн Засаг даргаас тайлант онд 646 захирамж батлагдсанаас нийтээр дагаж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гараагүй байна.</p> <p>Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 46 байгууллагын удирдах албан тушаалтнаас гаргасан сүүлийн 5 жилийн 11356 тушаал, шийдвэрийг хянан үзээд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр суманд 1, Засаг даргын дэргэдэх агентлагуудаас дөрвөн байгууллагын 5 шийдвэрийг хүчингүй болгуулсан.</p> <p>Аймгийн Засаг даргын захиргааны хэм хэмжээ тогтоосон өмнөх жилийн шийдвэрүүдэд хяналт шинжилгээ хийж, 2016 оны А/439 дүгээр захирамжаар хуулийн үйлчлэл хангахгүй аймгийн Засаг даргын 2005 оны “Эрүүл мэндийн өдөр болгох тухай” а/33, 2008 оны “Бүх нийтээр мод тарих өдөр тогтоох тухай” а/107, 2008 оны “Журам батлах тухай” а/156 дугаар захирамжуудыг тус тус хүчингүй болгож ХЗДХЯаманд хүргүүлэн Улсын нэгдсэн бүртгэлийн сангаас хасуулсан.</p>	100.0
1.5	Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгадаг байх;	<p>Аймгийн Засаг даргын “Бүтээлч Өвөрхангай-2020” үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөхүүдийн бүрэлдэхүүн, НҮБ-ын “Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийг судлах төв”-ийн зөвлөх баг, аймгийн хэлтэс, агентлагуудын удирдлага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн 330 гаруй санал, санаачлагуудыг тусгасан.</p> <p>Аймгийн Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Эрүүл мэндийн газар, 19 сумын Иргэний танхимд нийт 112 удаагийн хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 6000 гаруй иргэн хамрагдаж, хууль тогтоомжийн төсөлд санал авах, сурталчлах хэлэлцүүлгүүдийг зохион байгууллаа.</p>	100.0
1.6	Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;;	<p>Мэдээлэл, шуурхай удирдлагын төвд тайлант онд 1610 иргэн хандснаас гомдол 857, санал хүсэлт 70, мэдээлэл лавлагаа 684 хүлээн авсан байна.</p> <p>Арвайхээр хотын хөдөлгөөнт, чиглэлийн, машины дугаар илрүүлэгч гэсэн 3 төрлийн телекамеруудыг засварт орон нутгийн төсвөөс 1400.0 мянга төгрөг шийдвэрлэн гэрэлтүүлэг, харагдах орчинг сайжрууллаа. Тайлант онд камерын хяналтын системд нийт 518 гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дүрст бичлэг</p>	100.0

		<p>бүртгэгдснээс замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой 254 зөрчлийг илрүүлж, Замын цагдаагийн хэлтэст уламжлан шийдвэрлүүлсэн байна.</p> <p>Мөн хотын соёл, иргэний үүргийн хариуцлагыг зөрчсөн 734 зөрчлийг илэрүүлэн холбогдох байгууллагуудад хүргүүлэн шийдвэрлүүллээ.</p> <p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий “Иргэний зөвлөл”-ийг 7 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулан ажиллуулж байна.</p> <p>Иргэдээс төрийн үйчилгээтэй холбоотой санал, гомдлыг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан гэрээний хүрээнд “Соёмбо” “Арвайхээр”, “ЖИ ЭМ” телевизүүдээр “Асуудал шийдэл”, “Иргэдийн цаг” “Шилэн цаг” шууд нэвтрүүлгүүдээр долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв, Баасан гаргуудад хүлээн авч, түүний мөрөөр холбогдох байгууллагуудын удирдлага, мэргэжилтнүүдээс тухайн асуудлын талаар тодруулга авч цаг тухайд нь иргэдэд эргэн мэдээллэв.</p>	
1.7	Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх;	<p>2016 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтнуудад хандаж нийт 15146 өргөдөл, гомдол, санал ирүүлснээс өргөдөл 12906 буюу 85.2 хувь, гомдол 1001 буюу 6.6 хувь, санал 1239 буюу 8.1 хувийг тус тус эзэлж байна. Эдгээрийг хэлбэрийн хувьд авч үзвэл бичгээр 12396 буюу 81.8 хувь, утсаар хандсан 1610 буюу 10.6 хувь байна. Төрийн байгууллага, албан тушаалтнуудад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн нийт 15146 өргөдөл, гомдол, саналын 14677 буюу 96.9 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 3527 буюу 2.3 хувийг холбогдох байгууллагад шилжүүлж, 466 буюу 3.08 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна.</p> <p>Нийт ирсэн 151466 өргөдөл, гомдол, саналын 1503 буюу 9.9 хувь нь шилжилт хөдөлгөөнтэй холбоотой, 1221 буюу 8.06 хувь нь материал, мөнгөн тусламж хүссэн, 41 буюу 0.2 хувь нь сургууль, курст суралцах, 46 буюу 0.3 хувь нь гэр, орон сууц хүссэн, 1421 буюу 9.3 хувь нь ажилд орохыг хүссэн, 1906 буюу 12.5 хувь нь тэтгэвэр тогтоолгох, 9008 буюу 59.4 хувь нь тусгай болон газрын зөвшөөрөл, жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэхэд шаардагдах зээл олгохыг хүссэн, иргэний баримт бичгийн зөрчил арилгуулах, залруулах, нөхөн гэрчилгээ олгохыг хүссэн зэрэг бусад асуудлаар хүсэлтээ тус тус илэрхийлсэн байна.</p>	90.0
ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ			98.1